**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 21 өдөр Дугаар А/167 Хэрлэн сум

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор шуурхай бүлэг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2023 оны "Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын хуурайшилтын улирал эхэлж ой, хээрийн түймрийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд бүсчлэн ажиллах бүлгүүдийг ажиллуулсугай.

2.Бүлгүүдийн шатахуун, хоолны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Зардалд шаардагдах 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.Урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтэд хүртээмжтэй бүхий л төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат), бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2023

23101039

Аймгийн Засаг даргын 2023 оны
..03... дугаар сарын...21...-ны өдрийн
А/167.....дугаар захирамжийн хавсралт

## СУМДАД АЖИЛЛАХ ШУУРХАЙ БҮЛГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

| ХҮНСНИЙ ТООЦОО | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| д/д | хүнс бүтээгдэхүүний нэр төрөл | 1 хүний хоногийн хэмжээ /гр/ | ажиллах хүний тоо | нэг өдөрт /кг/ | өдөрт /2 хоол/ | ажиллах хоног / 30 / | нийт /кг/ | нэг бүрийн үнэ | бүгд үнэ |
| 1 | мах | 0.21 | 12 | 2.52 | 5.04 | 30 | 151 | 14000 | 2114000 |
| 2 | гурил | 0.12 | 12 | 1.44 | 2.88 | 30 | 86 | 3350 | 289440 |
| 3 | цагаан будаа | 0.04 | 12 | 0.48 | 0.96 | 30 | 29 | 5500 | 158400 |
| 4 | ургамлын тос | 0.025 | 12 | 0.3 | 0.6 | 30 | 18 | 11500 | 207000 |
| 5 | элсэн чихэр | 0.02 | 12 | 0.24 | 0.48 | 30 | 14 | 5000 | 72000 |
| 6 | гоймон | 0.02 | 12 | 0.24 | 0.48 | 30 | 14 | 10000 | 144000 |
| 7 | төмс | 0.10 | 12 | 1.2 | 2.4 | 30 | 72 | 2000 | 144000 |
| 8 | сонгино | 0.02 | 12 | 0.24 | 0.48 | 30 | 14 | 4200 | 60480 |
| 9 | Манжин | 0.02 | 12 | 0.24 | 0.48 | 30 | 14 | 4500 | 64800 |
| 10 | Лууван | 0.02 | 12 | 0.24 | 0.48 | 30 | 14 | 2900 | 41760 |
| 11 | байцаа | 0.04 | 12 | 0.48 | 0.96 | 30 | 29 | 4500 | 129600 |
| 12 | талх | 0.03 | 12 | 0.36 | 0.72 | 30 | 22 | 3500 | 75600 |
| 13 | хоол амтлагч /Цай,давс,вигор,сүү / | | | | | | | | 50000 |
| Нэг бүлэгт ноогдох хоолны дүн | | | | | | | | | **3551080** |
| 5 бүлэгт нийт | | | | | | | | | **17755400** |

| ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ТООЦОО | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хойд сумдад АИ-92 бензин | Явах маршрут | явах зай /км/ | шатахуун /л/ | нэгж үнэ | нийт үнэ |
| | | Бор-Өндөр-Галшар | 120 | 21.6 | 2520 | 54432 |
| | | Галшар сумын 5 багийн айл өрх | 258 | 46.4 | 2520 | 116928 |
| | | Чингис хот-Өнмөдэлгэр | 120 | 21.6 | 2520 | 54432 |
| | | Өнмөдэлгэр сумын 4 багийн айл өрх | 750 | 135 | 2520 | 340200 |
| | | Өнмөдэлгэр - Батширээт сум | 100 | 18 | 2520 | 45360 |
| | | Батширээт-4 багийн айл өрх | 450 | 81 | 2520 | 204120 |
| | | Батширээт-Биндэр сум | 70 | 12.6 | 2520 | 31752 |
| | | Биндэр сумын 5 багийн айл өрх | 500 | 90 | 2520 | 226800 |
| | | Биндэр -Баян-Адарга сум | 100 | 18 | 2520 | 45360 |
| | | Бэрх тосгоноос Дадал сум | 200 | 36 | 2520 | 90720 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Дадал сумын 3 багийн айл өрх | 105 | 18.9 | 2520 | 47628 |
| | | Баян-Адарга сумын 5 багийн айл өрх | 500 | 90 | 2520 | 226800 |
| | | Дадал сумаас Бэрх тосгон | 170 | 30.6 | 2520 | 77112 |
| | | Дүн | 3443 | **619.70** | **2520** | **1561644** |
| масло тос | | | | | | |
| 2 | нэг бүлэгт | | 0 | 2 | 12500 | 25000 |
| 5 бүлэгт нийт | | | | | | **125000** |
| СЭРЭМЖЛҮҮЛЭГ МАТЕРИАЛЫН ТООЦОО | | | | | | |
| 1 | Иргэдэд тараах материал | Санамж материалын нэр | тоо ширхэг | | нэгж үнэ | нийт үнэ |
| | | орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх шторк | 2 төрлийн | | 441000 | **882000** |
| | | Ой хээрийн түймэр | 3900 | | 1400 | **4676000** |
| | **Нийт дүн** | | | | | **25,000,000** |